НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022.12.01 Улаанбаатар хот

| № | ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэг жүүлэх байгуул лага | Эх үүсвэр | Нийт хөрөн гийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилт | Хэрэгжил тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая. төг) | Төсвийн (Гүйцэт гэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО<br>3.1.Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна. | | | | | | | | | | | | |
| 1 | МУХТ-4.4.1, НХТЖҮЧ-4.1.1 НЗДҮАХ-3.1.1 | Нийслэлийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 2022 он | НТаг, НГЗБА | - | - | Нийслэлийн 2021 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр газраас 65,990,4 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгөөс 49,649,5 сая төгрөг төвлөрүүлсэн. | Нийслэлийн төсөвт газраас 70,000.0, үл хөдлөх хөрөнгөөс 70,000.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна. | - | - | Сангийн сайд, хууль зүйн сайдын 1997 оны 102/51 дугаар хамтарсан тушаалын дагуу худалдан борлуулсан аливаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийг шилжүүлэн бүртгэхдээ үл хөдлөх эд хөрөнгө худалдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг төлсөн тухай оршин суугаа нутаг дэвсгэрийн татварын хэлтсээс баталгаажуулсан баримтыг хавсралт болгон авч байхыг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт даалгасны дагуу үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг төлсөн баримтыг авч бүртгэл хийж байгаа болно.<br>Нийслэлийн төсөвт 2022 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр үл хөдлөх хөрөнгийн татварт 50,392,513,203.0 төгрөг төвлөрүүлсэн байна.<br>Тус газар нь 2022 оны 11 дүгээр сарын байдлаар улсын төсөвт 9.9 тэрбум төгрөг, нийслэлийн төсөвт торгууль шийтгэврийн орлогод 1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. | 78.5 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО<br>4.1.Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | | | | | | | | | | | | |
| | НЗДҮАХ-4.1.4 | Нийслэлийн бүх хороодод иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээ, эд хөрөнгийн бүртгэлийн лавлагаа олгох үйлчилгээг үзүүлнэ. | 2022 он | НУБГ | Улсын төсөв | - | 2021 оны байдлаар 31 хороонд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. | Нийслэлийн 171 хороонд иргэний шинэчилсэн бүртгэл болон эд хөрөнгийн бүртгэлийн лавлагаа олгох үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна. | 95.0 | Тус газарт уг арга хэмжээтэй холбоотой төсөв суугдаагүй | Нийслэлийн 171 хорооноос иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн.<br>Хороодоос эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлын хүрээнд эрх зүйч мэргэжил бүхий хороодын улсын бүртгэгч нарын судалгааг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.<br>2022 оны 2 дугаар сарын 17-ноос 3 дугаар сарын 17-ны өдрүүдэд эрх зүйч мэргэжилгүй нийт 77 улсын бүртгэгч Дотоод хэргийн их сургууль дээр 2 ээлжээр сургалтанд хамрагдсан.<br>Мөн эрх зүйч мэргэжилтэй 111 улсын бүртгэгч 2022 оны 3 дугаар 15-наас 4 дүгээр сарын 19-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулагдсан цахим сургалтад хамрагдсан байна.<br>Нийслэлийн хороодын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрх нээсэн.<br>Нийслэлийн хороодод 2022 оны 11 дүгээр сарын байдлаар иргэний улсын бүртгэлийн 327805, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1115, нийт 328920 улсын бүртгэл хийгдсэн байна. | 100 |

НИЙСЛЭЛИЙГ 2022 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ 2022 ОНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОД ТҮВШИНГИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 3.1.Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна. | | | | | | | |
| 1 | Худалдах, худалдан авах гэрээний бүртгэлийн үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсаны орлогын албан татвар | сая. төг | НТаг, НГЗБА | 49,649.5 сая.төг | 70,000.0 сая.төг | 50,392,513,203.0 төг | 78.5% |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | |
| 4.1.Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | | | | | | | |
| 1 | а.Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн тоо.<br>б.Сургалтад хамрагдсан хорооны улсын бүртгэгчийн тоо. | тоо | НУБГ | а. 31<br>б. - | а. 171<br>б. 171 | а. 171<br>б. 188 | 100% |

---oOo---